



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

**Төрийн болон орон нутгийн өмчид  
эд хөрөнгө бүртгэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд байрлах 1911 онд баригдсан “Монголын анхны банкны барилга”-ыг нийт 44,290,700.00 (дөчин дөрвөн сая хоёр зуун ерэн мянга долоон зуун) төгрөгийн үнэлгээгээр Монгол банкны хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Монгол банкны Тамгын газрын захирал Г.Пүрэвсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Дээрх түүх соёлын үл хөдлөх дурсгалыг Соёлын өвийн тухай хуулийн дагуу хадгалах, хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД